

1. Улсын бүртгэлийн гэрчилгээтэй байх
2. Сургалтын хөтөлбөрийн агуулгад нийцсэн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх
3. Тухайн мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, багц цагийн богино хугацааны сургалтын чиглэлээр батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх;
4. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх журамтай байх
5. Стандартын шаардлага хангасан эмнэлгийн зориулалттай барилга байгууламжтай байх /мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагын хувьд сүлжээнд нэгдсэн нийт байгууллагад хамаарна/;
6. Сургалтын тухайн чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг эмчилгээ, оношилгооны тасаг нэгжтэй байх, орны тоо, үйлчлүүлэгчийн тоо сургалт эрхлэхэд хангалттай түвшинд байх;
7. Сургалтын чиглэлд нийцсэн сургалтын танхим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, лаборатори, мэргэжлийн номын сан, байнгын үйл ажиллагаатай хэвлэх, хувилах төхөөрөмж, интернэт бүхий компьютерийн танхим, суралцагчдад зориулсан амрах, хувцас солих өрөө гэх мэт сургалтын орчныг бүрдүүлсэн байх
8. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэвийн явуулах түвшинд орон тооны эмч, бусад мэргэжилтэнтэй байх;
9. Батлагдсан орон тоо бүхий сургалтын нэгж эсхүл төгсөлтийн дараахь сургалтын асуудал хариуцсан орон тооны ажилтантай байх;
10. Батлагдсан орон тоо бүхий эрдэм шинжилгээ, судалгааны нэгж эсхүл эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа хариуцсан орон тооны ажилтантай байх /тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт хамаарна/;
11. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхи бүхий багшлах бүрэлдэхүүнтэй байх, сургалт удирдах багшийн 70-аас доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх;
12. Эмнэл зүйн сургагч багшийн сургалтанд сургалт удирдах нийт багш суралцаж, төгссөн байх;
13. Тухайн чиглэлээр нэг жилд хэдэн суралцагч сургах хүчин чадлыг тооцсон 3-5 жилийн төлөвлөгөөтэй байх;
14. Эмнэл зүйн сургагч багшийн нөөц бүрдүүлэх, чадавхийг тасралтгүй сайжруулах 3-5 жилийн төлөвлөгөөтэй байх;
15. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний дотоод хяналт тогтмол явагддаг байх;
16. Мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагын хувьд сүлжээнд нэгдсэн нийт байгууллагын төлөөлөл бүхий сургалтын хяналтын зөвлөл байгуулсан байх;

Мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагын сүлжээний хувьд сургалт эрхлэх үндсэн байгууллага сүлжээнд нэгдсэн бусад байгууллагатай гэрээ байгуулсан байх;